

ХЯТАДЫН ШИНЭ ҮЕИЙН ФИЛОСОФИЙН ОНЦЛОГ

Р.Дарьхүү, МУИС.НШУС. Философийн тэнхим.профессор.

Түлхүүр үг: өөрчлөлт, агуу их нэгдэл / датун /, үндэстний зарчим, ардын засгийн зарчим, ардын жаргалын зарчим

Хятадын шинэ үеийн түүх нь 1840 оны хар тамхины дайнаар эхэлдэг бөгөөд 1911 онд Синьхайн хувьсгал гарч, анхны бүгд найрамдах улсыг байгуулах хүртэл үеийг хамаарна. Хятадын түүхийн нэн шинэ үе бол 1911 оноос 1949 оныг хамаарна.

Хятадын түүхэнд Чин улс /1644-1911/ хамгийн сүүлчийн хаант улс байв. Манж угсааны хаад төрийг удирдаж, Чин улс биеэ даасан нэртэй боловч гадаадын хөрөнгөтөн улсуудын хараат орон болж хувирсан байжээ.Тухайлбал, Шанхай нь хятадын газар нутаг дээрхи гадаадынхны их хот болжээ. Европын машинаар үйлдвэрлэсэн хямд бараа нь Хятадын гар урчууд, нэхмэлчдийн барааг унагаж,олон арван гар урчууд, нэхмэлчид үгүйрэн хоосорчээ.Тэр үед улс орон даяар баян нь хоосорч, хоосон нь өлсгөлөнд нэрвэгдэж, бүх юм уналтад оржээ. Гэвч эрх баригчид нь улс төрийн хувьд хаалттай хаалганы бодлогоо баримталж, өөрсдийгөө "Тэнгэрийн гүрэн" хэмээн хуучнаар сэтгэж байв. Гэтэл өрнө дахинд XVII зуунд Англид хөрөнгөтний хувьсгал гарч, XVII-XIX зуунд Европт капиталист хүчирхэг гүрнүүд бий болов. Эдгээр нөхцөл байдал нь нэг бол улс орон мөхөх, эсвэл дэлхийн хүчирхэг гүрнүүд шиг болохын тулд яах ёстой вэ гэсэн асуудлыг дэвшүүлэн тавьсан байна.

Тэр үед Английн зүгээс Хятадад эзлэн түрэмгийлэх үйл ажиллагаа явуулжээ. Үүний жишээ нь 1840 оны хар тамхины дайн болно. Энэ дайны талаар хожим Мао Зе Дун хэлэхдээ : "1840 оны хар тамхины дайны дараа Хятад улс аажмаар хагас колони, хагас феодалын орон болсон"¹ гэжээ. Гэхдээ энэхүү гадаадын колоничлогчдын эсрэг Хятадын ард түмэн байнга тэмцэл явуулжээ.Тухайлбал,

- 1850-1864 оны Тайпины бослого /Хун Сю Цюань/,
- 1898 оны Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн /Кан Ювэй/,
- 1911 оны Синьхайн хувьсгал /Жан Бин Лин/,
- 1919 оны 5 сарын 4-ний хөдөлгөөн /Сун Ят Сен/ гэх мэт.

Ийм түүхэн нөхцөлд шинэ үеийн философи нь боловсорчээ. Хятадын шинэ үеийн философийн гол төлөөлөгчид гэвэл: Гун Цзы Жэн, Хун Сю Цюань, Кан Ювэй, Жан Бин Лин, Янь Фу, Сун Ят Сен нарыг онцлон нэрлэж болно. Одоо эдгээр томоохон төлөөлөгчдийн үзэл баримтлалыг тус тусад нь товчхон тайлбарлая.

Шинэчлэгч үзлийг үндэслэгч Гун Цзы Жэн /1792-1841/ нь Хань Жоу-д газар эзэмшигчийн гэр бүлд төрсөн бөгөөд Хятадын шинэ үеийн нийгэм-улс төрийн зүтгэлтэн юм. Хүүхэд ахуй цагаасаа тэрбээр Күнзийн сургаалийг судалж, мөн өрнийн болон хятадын философийг сонирхон харьцуулан судалж, тэр үндсэн дээр түүний ертөнцийг үзэх үзэл

¹ Мао Цзедун. Избр. произв., т.3. М., 1953, с. 142.

төлөвшжээ. Түүний философийн гол үзэл санаа бол шинэчлэгч үзэл бөгөөд улс төрийн бодлогыг шинжлэх ухаантай холбох явдал мөн.

Гун Цзы Жэний үзлээр, орчин үеийн шинжлэх ухааны судлах зүйл нь улс орныг удирдах болон шинэчлэх арга замын тухай асуудал юм. Тэрээр "Төр бол амьд бие гэж үзээд, хятадын төрийн хувьд түүний дотоод эрхтнүүд нь хүндээр өвчилсөн байна. Гэвч эрх баригчид түүнийг эмчлэх тухай бодохгүй, харин ч өөрсдийн байр сууриа алдахгүйг хичээж, урт уяагаар түүний гар хөлийг холбож, үхэн хатан зууралдаж байна. Үүнээс болж манай нийгэм өдрөөс өдөрт улам суларч, мөхөл рүүгээ явж байна" хэмээн феодалын хүнд сурталт төрийг шүүмжилжээ.

Мөн тухайн үеийн нийгэм дэх баян ядуугийн ялгаа, ялангуяа ядуурал нь нийгмийн дэг журмыг алдагдуулж, үймээн самуун дэгдээж, мөхөлд хүргэх аюултай гэж тэрбээр үзсэн буй. Энэ нь нийгмийн хямрал доройтлын гол шалтгааныг эдийн засгийн тэгш бус байдалтай холбон үзсэн хэрэг юм. Ийм байдлыг зайлшгүй өөрчлөх шаардлагатай, "Эртний хууль ёс хэмээн сохроор мөрдөх нь юуг ч өөрчлөхгүй, эртний хууль ёс нь өнөөгийн хүнд хэцүү байдлыг өөрчилж чадахгүй"¹ хэмээн Гун Цзы Жэн үзээд, нийгэм байнга хувьсан өөрчлөгдөж шинэчлэгдэх ёстой гэжээ. Хүн төрөлхтний түүхийг эргэн судлахад өөрчлөлтгүй нийгэм, өөрчлөлтгүй хууль гэж хаана ч байхгүй гэжээ. Түүний үзлээр, "Нийгмийг өөрчлөх гол хүчин зүйл бол хүний оюун ухаан, шинжлэх ухаан мөн". Иймд Хятадад шинэчлэл, шинэ нийгэм байгуулах нь зайлшгүй чухал юм гэдгийг Гун Цзы Жэн анх олж харсан буй.

Хятадын шинэ үеийн философи дахь шашны философийн үзлийг баримтлагч Хун Сю Цюань /1814-1864/ нь Гуандун мужид тариачны гэр бүлд төрсөн бөгөөд тэрбээр 18 настайгаасаа багшийн ажил хийжээ. Тэрээр 1830 оноос Христийн шашин болон өрнийн философийг судалж, Хятадын уламжлалт философи болох күнзийн сургаал болон даосизмыг нийгмийн тэгш бус байдлыг номлосон хэмээн шүүмжилж, христийн шашны сургаал дахь бурхны өмнө бүгд тэгш эрхтэй байх тухай үзэл санааг уламжлан, "Бүх хүмүүс адил тэгш эрхтэй байх ёстой" хэмээх өөрийн философийн үзлийг боловсруулжээ.

Түүний үзлээр, "Төгс хүчит дээд эзэн хаан бол газар, тэнгэрт буй бүгдийг захирагч, ертөнц дээрхи цорын ганц жинхэнэ бурхан юм. Тэр нь хамгийн бишрэлт, агуу, хамгийн цэцэн ухаант, хамгийн алдарт бурхан болно". Түүнчлэн буддизмийг Хун Сю Цюань шүүмжлэхдээ: "Мод, чулуу, шаврын хэсэг зэргээр хүмүүсийн хийсэн болон цаасан дээр зурсан онгод бол хорон сүнс зүрх сэтгэлийг нь мунхруулсан хүмүүсийн гараар бүтээгдсэн бөгөөд тэд мунхаг оюун, мунхаг үзэлдээ жолоодуулан, өөрсдийнхөө гараар янз бүрийн дүрсүүдийг бий болгосон юм. Гэтэл тэдгээр бурхад нь амтай байтлаа ярьдаггүй, хамартай байтлаа үнэрлэх чадваргүй, чих байлаа ч сонсох чадваргүй, гартай мөртлөө юу ч барьж авч чаддаггүй, хөл байлаа ч явж чадахгүй тул түүнийг шүтнэ гэдэг тэнэг хэрэг" гэжээ.

Түүний амьдарч байсан цаг үе нь түүнийг улс төрд хөтлөн оруулжээ. Английн колончлогчдийн харгис үйл ажиллагаа, мөн Чин улсын эрх баригчдын арчаагүй дорой байдал, ард түмний амьдралын

¹ Гун Цзы жэ. цюаньцзи, И- бин чжи цзи чжуи ,

хүнд хэцүү байдал нь Хун Сю Цюаны үзэл санаанд хүчтэй нөлөөлжээ. Тэрээр "Өөрийн гарт засгийн эрхийг авч, нийгэм дэх худал хуурмагийн үндсийг тасалж, шударга үнэнийг сахиулж, ард түмнээ дорой байдлаас гаргая" хэмээн хатуу шийдэж, Тайпины бослогыг удирдаж байжээ. Энэхүү бослого буюу тариачдын дайн нь нийгэмд тэгш байдлыг тогтоож, "Тэгш жаргалант тэнгэрийн улсыг" байгуулах зорилготой байв.

Хун Сю Цюаны философийн нэг гол баримтлал бол тэнгэрийн хууль тасралтгүй хөдөлгөөн хувиралтад оршдог хэмээх баримтлал юм. Түүний үзлээр, "Үймээн самуун туйлдаа хүрэхээр сайн удирдлагаар солигддог. Харанхуй туйлдаа хүрэхээр гэрлээр солигддог. Энэ бол тэнгэрийн хууль. Харанхуй шөнө гэрэлт өдрөөр солигддогтой адил ертөнц дээрх бүх юм хөдөлж, өөрчлөгдөж, хөгжиж байдаг"¹.

Ийм учраас "Тэнгэрийн доорхи ертөнцийн хүмүүс бидний ах, эгч, дүү нар хорон муу санаа ноёлсон тамын хаалганаас гарч, дээд эзэн хааны заасан үнэний замаар тэнгэрийн хилэнгээс эмээж, тогтоосон хориг цаазыг нь хичээнгүйлэн дагаж, өөрийгөө болон бусдыг хамтдаа сайжруулж, хамтдаа засаж залруулж, хамтдаа голын дунд гүүрийн тулгуур мэт зогсож, хамтдаа хүчит давалгаанаас аврагдаасай гэж хүсч байна" хэмээн тэрээр өгүүлсэн буй. Түүнчлэн "Аахилан ирж буй давалгаанаас аврагдахын тулд "муу хэвшилтэй нийгмийг" өөрчлөхийг хүсвэл сэтгэлийн асар их хүч хэрэг болно, харин энэ бол нийгмийг зайлшгүй өөрчлөхийн дохио мөн" гэжээ.

Тэрээр Хятад орны ирээдүйн нийгмийн талаар хэлэхдээ: "Хэрвээ ямар нэг зүйлийг хийхдээ ертөнцийг нэгэн гэр бүл мэтээр үзэж, бусадтай хамт агуу амгалан тайванг эдлэн жаргахад зам нь нийлэхээ байсан хэвшил, алдаатай нийгэм аль хэр удаан тэсэж чадах вэ, тэрээр нэгэн сайхан өдөр үнэнч шударга нийгэм болон хувирахгүй гэж үү? Эзэрхийлэлт, дарлал, тэмцэл, аллага ноёлсон нийгэм аль хэр удаан тогтох вэ, нэгэн сайхан өдөр тэрээр хүчтэй нь хүчгүйгээ доромжилдоггүй, цөөнхи нь олонхио хүчирхийлэхгүй, ухаантнууд нь тэнэгүүдээ хуурахгүй, зоригтойчууд нь аймхай хулчгаруудаа айлгахгүй тийм нийгэм болон хувирахгүй гэж үү"² хэмээн утопи социалист маягийн үзэл санааг дэвшүүлсэн юм.

1853 оны 3 сард Хун Сю Цюань "Тэнгэрийн улсын тогтоосон газар эдлэх системийг" боловсруулж, юуны өмнө газрыг адил хэмжээгээр хүний тоогоор хуваарилах асуудлыг авч үзсэн. Олон ам бүлтэй гэр бүлд их, цөөн хүнтэй гэр бүлд бага газар ноогдохоор есөн бүлгээр хуваасан буй. Жишээлбэл, зургаан хүнтэй гэр бүлийн гурван хүнд нь сайн газар, гурван хүнд нь муу газар олгох нь шударга хэрэг гэжээ. Тэрээр хувийн өмчийг халж, нийтийн өмчтэй нийгэм байгуулахыг зорьжээ.

Түүний үзлээр, "Тэнгэрийн дор газар дээр хамгийн үнэтэй зүйл бол хүн өөрөө юм. Бүх амьтдын дотор хамгийн ухаантай нь хүн юм. Гэтэл хүмүүс яагаад өөрийгөө үнэтэй гэж үзэхгүй, эд юмсыг илүү үнэлдэг вэ, өөрийгөө ухаантай гэхгүй, бусдыг ухаантай гэж үздэг вэ, хэмээн өөрөө

¹ Хун Сю Цюань. Юаньдао синши сюнь

² Мөн тэнд

өөрийнхөө үнэ цэнийг ухаарч, өөрийнхөө хүчинд итгэж, өөрийн ухаантай амьдрахыг ард түмэндээ уриалж байжээ.”¹

Тэрээр “Төрийн албыг ээлжлэн хаших нь зүйтэй, учир нь энэ нь дээдэс ба доод давхрааныхан бие биенээ хуурч, албан тушаалаа зүй бусаар ашиглах явдлыг таслан зогсоох ач тустай” хэмээн үзээд, “Тухайн албан тушаалд тохирох хүнийг олж зөвлөсөн хүнийг шагнах, эсвэл тохирохгүй хүнийг зөвлөсөн бол тэр зөвлөсөн хүнийг шийтгэх нь зүйтэй” гэжээ.

Хун Сю Цюань эрэгтэй, эмэгтэй хүмүүс цэргийн алба хаах, төрийн албанд томилогдох, шалгалтад адил тэгш эрхтэй оролцох ёстой хэмээн үзэж байв. Энэ байр сууринаас Хятадын уламжлал ёсоор эмэгтэй хүн зөвхөн гурван зүйлийг сүслэн дагах уламжлалт ёсыг шүүмжилжээ. Тэрхүү ёсоор бол “Эмэгтэй хүн хүүхэд насандаа эцэгтээ, нөхөрт гарагд эр нөхөртөө, өтөл насандаа хүүдээ захирагдаж амьдрах ёстой” ажээ.

Хятадын шинэ үеийн философийн нэг томоохон төлөөлөгч болох Кан Ювэй /1858-1927/ нь Гуандун мужид газар эзэмшигчийн гэр бүлд төржээ. Тэрээр хүүхэд ахуй цагаасаа Хятадын уламжлалт философи, ялангуяа Күнзийн сургаал, Күнзийн шинэтгэсэн үзлийг сайтар судалсан буй. Хожим нь тэрээр эдгээр сургаалын үнэн эсэхэд эргэлзэж, өрнийн шинжлэх ухаан, философийг сонирхон үзсэн нь түүний шинэчлэлийн үзэл бүрэлдэхэд хүчтэй нөлөөлжээ.

Кан Ювэй нь өөрийн шинэчлэлийн үзлийг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө олон талт үйл ажиллагаа явуулсан байдаг. Тухайлбал, 1880 - 1898 онд Хятадын нийгмийг нэн даруй шинэчлэх шаардлагатай гэсэн илтгэлийг тэрээр эзэн хаанд долоон удаа өргөн барьжээ. Тэрхүү илтгэлүүдэд улс орны үндэсний тусгаар тогтнолд учирч буй аюулыг тодорхойлж, улмаар хаант засгийг халах, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, боловсрол, техникийн зэрэг бүхий л салбарт эрс шинэчлэл хийхийг шаарджээ. Ийнхүү эзэн хаанд шаардах бичиг өргөхийн зэрэгцээ тэрбээр Бээжин, Шанхай зэрэг томоохон хотуудад сонин хэвлэлээр дамжуулан сурталчилгаа хийх, “Улсаа хүчирхэгжүүлэх шинжлэх ухааны нийгэмлэгийг” байгуулан ажиллаж байв.

Энэ бүхний эцэст 1898 оны 6 сарын 10-нд эзэн хаан арга буюу шинэчлэл явуулах тунхаглал гаргажээ. Үүний үр дүнд хаант засгийг халж, шинэ Засгийн газрыг байгуулж, уг засгийн газрын бүрэлдэхүүнд Кан Ювэй, Тань Сытун нар болон шинэчлэлийн төлөө хөдөлгөөний төлөөлөгчид орсон түүхтэй. Гэвч энэ засгийн газар зөвхөн 100 хоног л оршин тогтнож, дараа нь уг хөдөлгөөнийг хүчээр нухчин даржээ. Түүний дараа Кан Ювэй гадаадад дүрвэн гарсан байна. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд тэрээр шинэчлэгч үзлээсээ ухарч, эзэн хааныг хамгаалах нийгэмлэг байгуулж, Сун Ят Сений удирдсан хөрөнгөтний ардчилсан хувьсгалын эсрэг тэмцэж, Синьхайн хувьсгалын дараа Күнзийн сургаалийг дэлгэрүүлэх үйл хэрэгт хүчин зүтгэжээ. Түүнийг Күнзийн үзлийг үргэлжлүүлэгч, шударга, үлгэр жишээч, “Цэцэн мэргэн Кан” хэмээн өргөмжилжээ.

Түүний философийн гол үзэл санаа бол аажим өөрчлөлтийн үзэл болно. Энэ талаар тэрээр Цин гүрний эзэн хаанд өргөсөн зургаа дахь

¹ Хун Сю Цюань. Юаньдао синши сюнь

илтгэлдээ тодорхой өгүүлсэн буй. Кан Ювэйн үзлээр, "Өөрчлөлт бол тэнгэрийн хууль. Тэнгэрт өдөргүй шөнө, хүйтэнгүй халуун гэж байхгүйн адил, энэ ертөнцөд өөрчлөгддөггүй юм гэж нэг ч байдаггүй. Өөрчлөлтийг зогсоож болохгүй. Нэг өөрчлөлтийг нөгөө өөрчлөлт дагаж байдаг. Хууль, жам ёсонд нийцсэн өөрчлөлтөөр аливаа зүйл хөгжиж цэцэглэдэг бол, хууль, жам ёсонд үл нийцэх өөрчлөлт нь сүйрэл мөхлийг дагуулдаг. Хэн ч байсан цаг үетэйгээ зохицон түргэн өөрчлөгдөх ёстой."¹

Кан Ювэйн философийн нэг үндсэн ойлголт нь "Агуу их нэгдэл"/"Датун"/² хэмээх ойлголт юм. Энэхүү ойлголтын гол агуулга бол ертөнц нэгдмэл. Улс орон нэг гэр бүл шиг нэгдмэл байх, мөн бүгд нэг дэг журамд захирагдах, хүн бүр өөрийнхөө төлөө биш, бие биенийхээ төлөө санаа тавьж хөдөлмөрлөх нэгдэж чаддаг байх явдал юм. Тэрээр нийгмийн хөгжлийн түүхийг судлаад, дараах гурван үед хуваажээ. Үүнд :

- Агуу их дэг журмын үе бол нийгэм эмх цэгцтэй, дэг журамтай тайван үе байв.
- Сул дорой үймээн самууны үе бол нийгэмд эмх цэгц дэг журам ихээхэн алдагдаж дайн байлдаанд автагдсан үе юм.
- Агуу их нэгдлийн үе бол ардчилал хөгжиж, бүх улс үндэстэн эв найрамдалтай байж, дайныг эсэргүүцсэн, нийгэмд шинэ дэг журам тогтсон үе болно.

Энэхүү агуу их нэгдэлд хүрэх арга зам нь :

- Хүмүүсийн оюун санааг өөрчилж, ссён гэгээрүүлэх,
- Ёс суртахууны хуулиудыг баримтлах,
- Гоо сайхны чадварыг дээшлүүлэх,
- Иргэдийн материаллаг хэрэгцээг хангах шаардлагатай гэж үзжээ.

Кан Ювэй тухайн үеийн нийгэм дэх зовлон зүдгүүрийн олон шалтгаан буйг тодорхойлжээ. Үүнд: өлсгөлөн, ган, үер, тарваган тахал зэрэг байгалийн шалтгаан, үхэл, ухаан муудах, бүдүүлэг ааш зан зэрэг биологийн шалтгаан, бэлэвсрэл, энчрөл, өвчлөл, ядуурал, сул дорой байдал зэрэг нийгмийн шалтгаан, цаазаар авах, албан татвар хураах зэрэг төрийн байгууллын шалтгаан, тэнэглэх, үзэн ядах, зэрэг мэдрэх чадварын шалтгаан, урт наслах, эрх мэдэлтэй болох, эд хөрөнгөтэй болох, алдар нэрэнд шунах, үхэшгүй мөнх буюу Будда шиг амьдрах зэрэг хүслийн шалтгаан эдгээр болно.

Хятадын шинэ үеийн философийн түүхэнд өрнийн философийн нөлөөг хүчтэй сурталчилсан хүний нэг болох Янь Фу /1853-1921/ нь долоон настайдаа уншиж бичиж сурсан бөгөөд 14 настайдаа тэнгисийн цэргийн сургуульд англи хэл, математик, хими, астрономи, хараа зүй, физик зэргийг эрчимтэй суралцаж их зүйлийг мэдэж авчээ. Мөн тэрээр Англид өрнийн техникийн болон хүмүүнлэгийн ухаанд сайтар суралцаж, эх орондоо буцаж ирээд, Ч.Дарвины "Эволюцийн онол", Г.Спенсерийн "Социологи", А.Смитийн "Улс түмний баялаг", С.Миллийн "Эрх чөлөөний тухай", ба "Логикийн систем", Ш.Монтескьегийн "Хуулийн дээд санаа", Д.Жевоны "Логикийн лекцүүд" зэрэг олон бүтээлийг орчуулж, Хятадын

¹ Кан Ювэй. Шан Цин -- ди лю шу.

² Кан Ювэй. Датун шу.

ард түмэн өрнийн философи болон шинжлэх ухаантай танилцахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

Түүний философийн гол үзэл нь материалист, эмпирик, социал-дарвинист үзэл юм. Янь Фугийн үзлээр, "Хүн бол ямар ч эргэлзээгүй байгалийн амьтан юм. Бүхий л зүйл амьдралын төлөө тэмцэж, байнга хувьсан өөрчлөгдөж, эцэстээ мөхдөг. Харин тэдгээрийн үндэс нь туйлын, үл өөрчлөгдөх, үл сэтгэгдэх бөгөөд бүхий л юмс үзэгдлийн мөн чанар нь болдог тэр зүйлийг дао"¹ хэмээн нэрлэсэн буй. Тэрээр өрнийн логикийн шинжлэх ухаан нь шинжлэх ухаануудын шинжлэх ухаан юм гээд, юмс үзэгдлийн мөн чанарыг танин мэдэх чухал арга нь индукц, дедукцийн арга гэж үзжээ. "Өнөөгийн түвшинд шинжлэх ухааны үнэнийг ам, хэл үгээр бус, харин гагцхүү туршилтын баримтын тусламжтайгаар батлах хэрэгтэй. Ингэснээр жинхэнэ мэдлэгийн хүрээнд орж, үнэнд хүрнэ. Судалгааны үйл явц нь ямар нэгэн урьдаас таасан сайхан үзэл бодол, сайхан үг яриа, нэгдэж тогтсон үзэл бодол, бодомж, ойлголтоор явагдаж болохгүй."

Янь Фугийн үзлээр, "Жинхэнэ шударга нийгэм бол эрх чөлөөтэй, элдэв харгис хууль тогтоомжоос татгалзах, чөлөөтэй сэтгэх, хүмүүсийг дээд, доод гэж ялгаварлахгүй, удирдагчид нь хэтэрхий их эрх ямба эдлэхгүй байх, ард түмэн нь нэгдмэл байх явдал юм. Ард түмэн бол улс орны жинхэнэ эзэд. Улс оронд гагцхүү ард түмний засаглал байж л эрх чөлөө нь баталгаажна. Хүний эрх чөлөөг хязгаарлах нь байгалийн хуулийг зерчиж буй хэрэг бөгөөд энэ нь хүнлэг ёсонд хохирол учруулдаг".

Энэ үеийн философийн нэг нэрт төлөөлөгч Сүн Ят Сен /1866-1925/ нь Гуандун мужид тариачны гэр бүлд төрсөн, Хятадын анхны ерөнхийлөгч юм. Тэрээр 1884-1886 онд Гонконгд Анагаахын коллежэд эмчийн мэргэжил эзэмшсэн бөгөөд залуугаасаа улс төрийн амьдралд оролцож, 1894 онд Япон-Хятадын дайнд Хятад улс ялагдахад, улс орны нөхцөл байдал хүнд байгаад санаа зовж, улс орноо өөрчлөн шинэчлэхийн төлөө түүний улс төрийн идэвхи улам ч их өссөн байна. 1900 онд тэрээр зэвсэгт бослого зохион байгуулж, ялагдсан тул Японд дүрвэж байв. Сүн Ят Сен Японд байхдаа улс орныхоо ирээдүйн төлөө эвлэлдэх холбоо байгуулж, гол зорилго нь Манжийн төрийг унагах, Хятадын ард түмэнд аз жаргал олгох явдал байв. Тэрээр 1911 оны Синьхайн хувьсгалыг удирдан зохион байгуулж, Хятадын түүхэнд хаант төрийг бүгд найрамдах төрөө сольж, анхны ерөнхийлөгчөөр ажиллажээ.

Тэрээр 1925 онд өвчний учир нас барсан байна. Түүний гол зохиол бүтээлүүд нь: "Хятадын хувьсгалын тухай тэмдэглэлүүд", "Ард түмний гурван зарчим", "Сүн Вэний сургаал" зэрэг болно.

Түүний философийн үзэл нь материалист үзэл болно. Түүний үзлээр, ертөнц нь материйн хувьсал, амьтдын хувьсал, хүний хувьсал хэмээх гурван үе шатыг дамжин хөгжиж иржээ. Материйн хувьсал нь "Агуу их өөрчлөлтөөс" /Тай-зы / эхэлдэг. Энэ бол материаллаг анхдагч эхлэл юм. Түүний хөдөлгөөний үр дүнд электронууд үүссэн, электронууд нь хоорондоо бөөгнөрч, химийн элемент бий болсон. Химийн элемент нь нэгдмэл бодисыг үүсгэж, тэрхүү бодис нь масстай болж, улмаар ертөнц

¹ Янь Фу. Юаньцян

үүссэн хэмээн тайлбарласан буй. Энэ ертөнц эхлээд хий мананцарын байдалтай байсан бөгөөд нар гарч агшилтанд орсноор мананцар нь хуваагдаж, тэдгээр нь удаан хугацааны явцад хувирч, шингэн бодис нь өтгөрөн хувирч, хатуу бодис үүссэн гэх зэргээр авч үзжээ.

Сүн Ят Сен амьдрал хэрхэн үүссэнийг дараах байдлаар тайлбарлажээ. Анх үүсэхдээ маш энгийн бүдүүлэг амьтад байв. Амьдралыг үүсгэгч анхдагч элементийг тэрээр "Шен-юань" хэмээх ойлголтоор тэмдэглэжээ. Энэ нь маш жижиг, нууцлаг гайхалтай бодис бөгөөд эс гэдэг ойлголттой ойролцоо утгатай юм. Хүний үүсэл хөгжлийн талаар Сүн Ят Сен үзэхдээ: "Хүн эхлээд адгууснаас ялгарахгүй байсан. Олон арван мянган жилийн байгалын шалгарал, хувьслын үр дүнд орчин үеийн хүн бий болсон. Хүнийг бурхан бүтээгээгүй. Хүн бол байгалийн бүтээл. Иймд байгалийн хууль нь хүний нийгмийн хөгжлийн хууль юм." Энэ бүхнээс үзэхэд Сүн Ят Сен бол материаллаг ертөнц анхдагч хэмээх үзлийг баримтлагч мөн.

Түүний үзлээр, танин мэдэхүйн үндэс, мэдлэгийн эх сурвалж нь туршлага юм. Онол бол туршлагаас, амьдралаас өмнө байгаагүй. Гагцхүү амьдралын баримт, туршлага л онолыг төрүүлдэг. Үнэн зөв мэдлэгийг амьдралын туршлагаас болон шинжлэх ухаанаас олж авна. Мэдэх бол хялбархан, харин хийх нь амаргүй зүйл байдаг. Хүмүүсийн үйл ажиллагаа янз бүр байдаг. Зарим нь огт мэдлэггүйгээр хийдэг, энэ нь ихэнхдээ сөрөг үр дагавар авчирдаг. зарим нь хийх явцдаа мэдлэг олж авдаг, зарим нь мэдлэгтэйгээр хийдэг. Бодит баримт бол үнэний шалгуур болно. Сүн Ят Сен хэлэхдээ: "Хүн бол оюун ухаанлаг аппарат юм. Хүмүүсийг оюун ухаанаар нь: ухаантан, ухаантны санааг ухуулагчид, гүйцэтгэгчид хэмээн гурав ангилж, тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг янз бүр байна" гэжээ. Улс гүрэн бол хүмүүсийн нийтлэг бөгөөд цогц утгаараа оюун ухаанлаг аппаратуудын нийтлэг юм.

Түүний нийгэм-улс төрийн гол үзэл санаа бол үндэстний зарчим, ардын засгийн зарчим, ардын жаргалын зарчим хэмээх гурван зарчим юм. Үндэстний зарчим нь Хятад үндэстэн биеэ даасан тусгаар тогтносон үндэстэн байх шаардлага юм. Ардын засгийн зарчим нь Хятад улсыг хөгжүүлэе гэвэл Бүгд Найрамдах Улсыг байгуулах шаардлага болно. Ардын жаргалын зарчим нь ард түмний сайн сайхны тулд нийгэм дэх тэгш бус байдлыг арилгах, нийгэмд тэгш байдлыг тогтоох шаардлага ажээ.

Түүний үзлээр, "Төр бол нүсэр том машин. Төрийн түшмэлүүд тэр машиныг жолооддог. Төрийн хууль нь тэр машиныг засч сайжруулдаг. Тэр машины мотор буюу хөдөлгүүр нь Засгийн газар, засгийн газрын хөдөлгөгч хүч нь ард түмэн. Ард түмэн хөдөлгөөнд оруулсан машинаа зогсоох, өөрчлөх, шинэчлэх эрхийг эдлэх ёстой. Энэ эрх нь төрийг хянах эрх юм. Ард түмэн төрөө хянаж байхын тулд засгийн газрыг байгуулах, хууль санаачлах болон хууль тогтоох, засгийн газрыг огцруулах үүрэг эрхийг эдлэх хэрэгтэй" ажээ.

Энэ бүхнээс эцэст нь дүгнэж хэлбэл, хятадын шинэ үеийн философийн онцлог нь :

¹ Сунь Чжуншань сюаньцзи, т. 1

- Өрнийн математик, физик, химийн шинжлэх ухааны ном бүтээлүүд олноор орчуулагдаж, одон орны тухай Н.Коперникийн сургаал, Ч.Дарвины хувьслын онол, И.Ньютоны сонгодог механикийн онол, Английн болон Францын философи, шинжлэх ухааны нөлөө хүчтэй болсон,
- Өөрийн уламжлалт философийг өрнийн философийн нөлөөнөөс хамгаалах үзэл санаа ч хүчтэй байв,
- Тухайн үеийн нийгмийн өмнө тулгамдсан олон асуудлыг судалж, шийдвэрлэх арга замыг шинээр тайлбарласан зэрэг болно.

Ном зүй

- В.Г.Буров.Современная Китайская философия. М., 1980
- Великие мыслители Востока.М., 1999
- Дундад улсын гүн ухааны хураангуй түүх. Хөх хот., 1999
- История Китайской философии. М., 1989
- Избранные произведения прогрессивной Китайской мыслители нового времени./1840-1898/. М., 1961
- Мао Цзе дун. Избр.произв., т. 3. М., 1953
- Н.Г.Сенин.Общественно-политические и философские взгляды Сун Ят Сена. М., 1963